

ҮАГ

Гүйцэтгэлийн аудитын тайлан

2004 оны 11 дүгээр
сар

**Ногдуулсан татвар бүрэн
төлөгдөхгүй байна**

**Улсын төсвийн албан
татварын орлогын бүрдүүлэлт**

Улаанбаатар хот

Агуулга

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	4
Аудитын стандартын талаархи мэдэгдэл	4

Аудитын дүн

Аж ахуйн нэгж байгууллагын орлогын болон гаалийн албан татварын ногдуулалт, төлөлт	5
Татварын бааз суурийг өргөжүүлэх, татварын тогтолцоог боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэийжээ, үр дүн	9
Татварын ногдуулалт, төлөлтөд тавих дотоод хяналтын тогтолцоо, түүний чанар үр нөлөө	15
Татварын бүртгэл, мэдээллийн тогтолцооны найдвартай шуурхай байдал	20

Дүгнэлт

23

Холбогдох байгууллагын санал

Үндэсний татварын ерөнхий газрын санал	25
Улсын гаалийн ерөнхий газар	26

Зөвлөмж

27

Агуулга

Тайланд гарах товчилсон үгс

СЭЗЯ	Санхүү эдийн засгийн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ДБЯ	Дэд бүтцийн яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газрын 2004 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн дагуу улсын төсвийн албан татварын орлогын бүрдүүлэлтэд аудит хийв.

Энэхүү аудит дараахь зорилттой байв. Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын болон Гаалийн албан татварын ногдуулалт, төлөлт хууль тогтоомжийн дагуу хийгдэж буй эсэх;
2. Татварын бааз суурийг өргөжүүлэх, татварын тогтолцоог боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүнг судалж дүгнэх;
3. Татварын ногдуулалт, төлөлтөд тавих дотоод хяналтын тогтолцоо, түүний чанар, үр нөлөөг судалж дүгнэх;
4. Татварын бүртгэл, мэдээллийн тогтолцооны найдвартай, шуурхай байдлыг үнэлж, дүгнэх.

Аудитад Үндэсний татварын ерөнхий газар, түүний харъяа татварын газар, зарим аймаг, дүүргийн татварын хэлтсүүд, Улсын гаалийн ерөнхий газар, түүний харъяа гаалийн хороо, зарим аймгийн гаалийн газрууд хамрагдлаа.

Гүйцэтгэлийн аудитад ярилцлага хийх, түүвэрчилсэн судалгаа явуулах, давтан гүйцэтгэх, нөхцөл байдлын шинжилгээ хийх, баримт материалыг тулган баталгаажуулах, ажиглалт хийх, гүйцэтгэлтэй нь харьцуулах зэрэг арга зүйг ашигласан болно.

Гүйцэтгэлийн аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр хэлтсийн дарга, тэргүүлэх аудитор Д.Ганбилэг удирдаж, тус хэлтсийн ахлах аудитор Г.Цэдэнбалжир, аудитор Ц.Батбаяр, Ц.Цэрэнхүү, шинжээч Б.Болормаа нар 2004 оны 9 дүгээр сарын 6-наас 11 дүгээр сарын 25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Ерөнхий зүйл

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Дараахь хууль тогтоомжийн холбогдох заалтыг энэхүү аудитад шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
- Нэгдсэн төсвийн тухай хууль
- Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2002 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 230 дугаар тушаалаар баталсан “Төвлөрсөн төсвийн орлого, хяналтын газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын хэлтэс (газар)-ийн 2003 оны үйл ажиллагаа, гүйцэтгэлийн стандарт”
- Гаалийн тухай хууль
- Гаалийн тарифын тухай хууль

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Энэхүү аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн шалгалтын журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын дүн

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын болон гаалийн албан татварын ногдуулалт, төлөлт

Санхүү, эдийн засгийн яамны (хуучин нэрээр) тайлангаар Монгол Улсын төсвийн орлогын 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын гүйцэтгэл 68781,4 сая төгрөгт хүрч 2003 оны ДНБ-ний 5 хувийг эзэлж байна.

Үндэсний татварын ерөнхий газар 2003 оны аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тайлангийн ногдуулалтаар 60690,3 сая төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оноос 129,5 хувь буюу 13840,0 сая төгрөгөөр нэмэгджээ.

Үндэсний татварын ерөнхий газрын 2003 оны ногдуулалтаар тооцсон аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын төлөлт Санхүү, эдийн засгийн яамнаас гаргасан дээрх гүйцэтгэлээс 8091,1 сая төгрөгөөр дутуу мэдээлэгдсэн байна. Үүнд:

СЭЗЯ, Монгол-Оросын хамтарсан Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн хооронд 2003 оны 12 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан хамтран ажиллах тухай гэрээний дагуу 15022,6 сая төгрөгийг Төв төрийн сангийн дансанд төвлөрүүлж, тайлант оны төсвийн орлогын гүйцэтгэлийн мэдээ, тайланд тусгажээ.

Тус үйлдвэр, Үндэсний татварын ерөнхий газрын Төвлөрсөн төсвийн орлого хяналтын газартай хийсэн 2003 оны албан татвар ногдуулах тооцооны дагуу орлогын албан татварт 24821,3 сая төгрөг, ашигт малтмалын нөөцийн төлбөрт 2937,7 сая төгрөг, газрын төлбөрт 1519,1 сая төгрөг, 2002 оны жилийн эцсийн тооцоогоор гарсан төрийн өмчийн ногдол ашгийн дутууд 6819,3 сая төгрөг, бүгд 36097,4 сая төгрөгийн орлого төсөвт оруулах, НӨАТ-ын тайлангаар 7106,5 сая төгрөгийн орлого илүү төлөлттэй гарахаар тус тус тооцсон байна.

Дээрх тооцооны дагуу 2003 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 23642,3 сая төгрөг, ашигт малтмалын нөөцийн төлбөрт 2937,7 сая төгрөг, газрын төлбөрт 1519,1 сая төгрөг, 2002 оны жилийн эцсийн тооцоогоор гарсан төрийн өмчийн ногдол ашгийн дутууд 1605,0 сая төгрөг, бүгд 29704,1 сая төгрөгийн орлого төсөвт оруулсан байна.

2003 оны эцэст аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тайлангийн ногдуулалтаас 1179,0 сая төгрөг, төрийн өмчийн ногдол ашгийн дутуу 5214,2 сая төгрөг, бүгд 6393,2 сая төгрөг дутуу төлжээ.

“Мобиком” корпораци Төв төрийн сангийн дансанд 2003 онд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвараар 5758,8 сая төгрөг оруулсан байна.

Аудитын дүн

Гэтэл татварын ногдуулалтаас 1504,5 сая төгрөг илүү төвлөрүүлснийг тайлангийн ногдуулалтаар төсөвт дутуу төвлөрсөн нэмэгдсэн өртгийн албан татвар, “Мобиком” корпорацид хувь хөрөнгө нийлүүлэгчдэд жилийн үр дүнгээр хуваарилсан хувь хүртэгчийн орлогод 20 хувиар тооцож ногдуулсан албан татварт тус тус суутган тооцсон байна.

“НИК” ХК 2003 оны аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвараар 127,6 сая төгрөгийг Төв төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Тус компани тухайн жилийн санхүүгийн тайлангаар алдагдалтай ажиллаж, орлогын албан татварын ногдолт гараагүй тул аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвараас хасч, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалтын дутууд дээрх орлогыг суутган тооцжээ.

“Эрдэнэт-Булганы Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХ Компани 2003 оны аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвараар 352,3 сая төгрөгийг Төв төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

“Эрдэнэт-Булганы Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ий жилийн тайлангийн ногдолт нь 11,0 сая төгрөг болж, илүү төвлөрүүлсэн 341,3 сая төгрөгийн орлогыг өмнөх оны хяналт шалгалтын актын дутуу төлбөрт тооцжээ.

Ийнхүү төсвийн жил, татварын хуулийн хугацаатай холбогдож татварын мэдээ, тайлан зөрүүтэй гарч байгаад дүгнэлт хийж, татвар төлөгчид болон олон нийтэд татвар төлөлтийг үнэн зөв мэдээлж байх хугацааг хуульчилж өгөх нь зүйтэй юм.

Үндэсний татварын ерөнхий газрын ногдуулалтаар тооцсон аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын 70,5 хувь буюу 42780,0 сая төгрөгийг Төвлөрсөн төсвийн орлого хяналтын газар, 27,2 хувь буюу 16524,4 сая төгрөгийг, нийслэл, дүүргийн татварын хэлтсүүд, 2,3 хувь буюу 1385,8 сая мянган төгрөгийг аймгийн татварын хэлтсүүд тус тус оруулсан байна.

Үндэсний татварын ерөнхий газар тайлант хугацаанд ногдуулсан татварын 90-ээс доошгүй хувийг хураан барагдуулах зорилттой ажилласан бөгөөд тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тайлангаар ногдуулсан татварын 86,9 хувь буюу 38773,3 сая төгрөгийг төлүүлсэн байна.

Аудитын дүн

Татвараа төлж чадаагүй татвар төлөгчдийг эрхэлж байгаа үйл ажиллагааных нь чиглэлээр авч үзвэл, нийт тасалдлын 20,5 хувь нь үйлчилгээний чиглэлийн 3 компани, 12,8 хувь нь арилжааны 9 банк, 24,5 хувь нь уул уурхайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 3 үйлдвэрт тус тус ногдож байна.

Татварын ерөнхий хуулийн 9.2-т: “...Татвар төлөх, тайлагнах эцсийн хугацаа адил байна” гэсэн заалтын дагуу 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2 дугаар сарын 10-ны өдрийн хооронд нийт дутуу төлөлтийн 48,4 хувь буюу 2985,2 сая төгрөгийг 83 аж ахуйн нэгж, байгууллагууд он дамжуулан төлсөн ба бусад нь хуулийн хугацаанд төлбөрөө барагдуулаагүй байна.

Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2002 оны 230 дугаар тушаалаар баталсан “ татварын тайлангаар ногдуулсан татварын барагдуулалт 90,0-ээс доошгүй хувь байна” гэсэн гүйцэтгэлийн стандартыг Төвлөрсөн төсвийн орлого хяналтын газар хангаж ажиллаагүй байна.

Үндэсний татварын ерөнхий газар удаан хугацаанд хуримтлагдсан татварын өртэй зарим аж ахуйн нэгжүүдийн өрийг тэдний үл хөдлөх эд хөрөнгөөр төлүүлж барагдуулсан байдалтай аудитын явцад танилцав.

Тухайлбал Орхон аймгийн татварын хэлтэстэй харилцагч олон жилийн хуримтлагдсан өртэй “Эрдэнэт-Од” ХХК-аас Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 132 дугаар тушаалаар 2 айлын орон сууцыг 7,6 сая төгрөгөөр, “Эрдэнэт хүнс” ХХК-иас Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 190 дүгээр тушаалаар Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний цогцолборыг 613,5 сая төгрөгөөр, “Строй инвест” ХХК-иас Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 208 дугаар тушаалаар 20 айлын орон сууцыг 700,0 сая төгрөгөөр тус тус үнэлэн бүгд 1321,2 сая төгрөгийг татварын өрөнд суутган авах шийдвэр гарчээ.

Дээрх шийдвэрийн дагуу улсын төсвийн татварын орлого болон хөрөнгө оруулалтын зардлыг 1313,6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн улсын төсвийн орлого, зарлагад холбогдох бичилт хийхийг Санхүүгийн зах зээл, салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн сангийн газарт тус тус даалгасан байна.

Аудитын дүн

Орхон аймгийн татварын хэлтэс урьд оны татварын өрийг 2004 оны 6 дугаар сарын 30-ны суутган тооцоогоор 7,6 сая төгрөг, 9 дүгээр сарын 30 –ны суутган тооцоогоор 1313,6 сая төгрөг, бүгд 1321,2 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Татварын ерөнхий хуулийн 9. 1-д: *“Татварыг татварын тайлан буюу орлого, татвар тодорхойлох хуудсаар, эсхүл суутгал хийх замаар ногдуулж, төлбөрийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр гүйцэтгэнэ. Энд зааснаас өөрөөр татвар ногдуулж төлөх журмыг тухайн төрлийн татварын хуулиар тогтооно”* гэсэн заалтыг зөрчиж байгаа тул цаашид татварын өрийг үл хөдлөх эд хөрөнгөөр хэт хавтгайруулан төлүүлж барагдуулахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай юм.

2003 онд Гаалийн ерөнхий газрын системийн байгууллагуудын хэмжээнд гаалийн татварын ногдуулалт 176748,9 сая төгрөг байхад хураалт 171437,0 сая төгрөг болж 5311,9 сая төгрөг буюу 3,0 хувиар ногдуулалтаас бага байна.

Энэ нь дараахь гаалийн байгууллагуудтай холбоотой байна. Үүнд:

- Улаанбаатар хот дахь Гаалийн газар гаалийн татварын ногдуулалт барагдуулалтаас 3998,4 сая төгрөгөөр давж байгаа нь “ТМД” ХХК-ны 1385,2 сая төгрөгийн татвар дараа онд төлөгдөхөөр хойшлогдсон, 2613,1 сая төгрөг 2004 оны эхэнд төлөгдсөнөөс шалтгаалжээ.
- Увс аймаг дахь гаалийн хороо 299,2 сая төгрөгийн гаалийн татварын ногдуулалтыг цаг хугацаанд нь төсөвт төвлөрүүлээгүй, баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ компани татварын өрийг барагдуулаагүй байна.
- Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар 2003 онд татварын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, татварын харилцах дансанд 66,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч, 44,6 сая төгрөгийн татварын орлого дараа онд шилжиж орсон байна.

Зөвхөн дээрх гаалийн байгууллагын ногдуулсан гаалийн татвараас барагдуулаагүй татварын үлдэгдэл 4408,4 сая төгрөг нь нийт барагдуулаагүй татварын орлогын 80,7 хувийг эзэлж байна.

Аудитын дүн

Татварын бааз суурийг өргөжүүлэх, татварын тогтолцоог боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн

Гаалийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт гаалийн татварын орлогын бүрдүүлэлт, гаалийн үйл ажиллагаатай холбогдож зарим аж ахуйн нэгж байгууллагад хийсэн гүйцэтгэлийн аудитаар гаалийн хууль, тогтоомж зөрчсөн 4 байгууллагад бүгд 14132,0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо. (Жагсаалтыг хавсаргав)

2003 онд улсын төсөвт орсон гол 4 нэр төрлийн орлогын албан татвар өмнөх оныхоос 45458,7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүн амын орлогын албан татварын бүрэлдэхүүнд ордог цалин хөлсний орлогын албан татварыг орон нутгийн төсвийн орлогод орж байсныг өөрчилж, улсын төсвийн орлогод оруулахаар татварын ерөнхий хуулинд тусгасан нь 2003 онд хэрэгжсэн байна.

Зарим нэр төрлийн татварын орлого

(Мянган. төгрөгөөр)

№	Татварын төрөл	2002	2003	Өсөлт
1	ААНБОАТ	46850255,9	60690328,8	13840072,9
2	ХАОАТ		24113942,8	24113942,8
3	НӨАТ	40582469,5	48268730,7	7686261,2
4	ОАТ	20478256,5	20296743,7	(181512,8)
	Бүгд	107910981,9	153369746,0	45458764,1

Татвар төлөгчдийг бүртгэлд хамруулах ажлын хүрээнд татвар төлөгчдийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудын харилцах дансны тооллогыг жил бүр явуулж ирсний үр дүнд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар төлөгчдийн тоо 108,9 хувиар буюу 1886 нэгжээр, иргэний орлого, татвар тодорхойлох хуудсаар тооцоо хийгчдийн тоо 112,3 хувиар буюу 6008 нэгжээр, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчдийн тоо 114,0 хувиар буюу 564 нэгжээр тус тус нэмэгдсэн байна.

Зарим нэр төрлийн татвар төлөгчдийн тоо

№	Татвар төлөгч	2002	2003	Өсөлт (хувь)
1	ААНБОАТ төлөгч	21032	22918	108,9
2	ИОТТХ-аар тооцоо хийгч	48692	54700	112,3
3	НӨАТ Төлөгч	4018	4582	114,0
4	ОАТ төлөгч	178	178	100,0
	Бүгд	73920	82378	111,4

Ийнхүү улсын төсөвт орох татварын орлого болон татвар төлөгчдийн тоо өмнөх оноос нэмэгдэж, татварын суурь өргөжиж байна.

Аудитын дүн

Үндэсний татварын ерөнхий газар алдагдалтай буюу “Х” тайлан гаргасан, тайлангаа хугацаандаа ирүүлээгүй татвар төлөгчдийн хувьд өөртөө байгаа мэдээллийн баазад тулгуурлан татварыг тодорхойлох ажлыг тус оноос эхлэн хэрэгжүүлсэн байна.

Иргэний орлого, татвар тодорхойлох хуудсаар татварын тооцоо хийвэл зохих иргэдийн судалгаа гарган Хүн амын орлогын албан татварт хамрахгүй байгаа иргэдийг татварт хамруулах ажил зохиож байна.

Дээрх арга хэмжээний үр дүнд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тайлан хүлээн авалт 2003 онд өмнөх оныхоосоо 0,7 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан хүлээн авалт 1,0 хувиар, иргэний орлого, татвар тодорхойлох хуудас хүлээн авалт 25,0 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Тайлангийн ирцийн судалгаа

№	Татварын тайлан	Тайлангийн ирц				Тайлангийн ирцийн жилийн дундаж хувь	
		Тайлан ирүүлбэл зохих		Тайлан ирүүлсэн		2002 он	2003 он
		2002 он	2003 он	2002 он	2003 он		
1	ААНБОАТ-ын тайлан	21032	22918	19646	21573	93,4	94,1
2	НӨАТ-ын тайлан	4018	4582	3948	4546	98,2	99,2
3	ОАТ-ын тайлан	179	180	179	147	100	81,7
4	ИОТТХ хүлээн авалт	48692	54700	28477	45821	58,5	83,8

Үндэсний татварын ерөнхий газрын хэмжээгээр татвар төлөгчдөөс онцгой албан татварын тайлангаас бусад татварын тайлан гаргалт урьд жилээс дээшилсэн байна.

Үндэсний татварын ерөнхий газрын Татварын удирдлага, арга зүйн хэлтэс 2003 онд татварын тогтолцоог боловсронгуй болгох ажлын хүрээнд татварын ачааллыг бууруулах, үр ашиг багатай хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах, татварын хуулиудын заалтыг нэг мөр болгон ойлгож хэрэгжүүлэх талаар доорхи ажлыг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Татвар төлөгчдийн татварын ачааллыг бууруулах зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт төлсөн татварыг татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар ногдуулах орлогоос хасч тооцдог байхаар Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Аудитын дүн

Энэ арга хэмжээг авснаар аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар төлөгчдийн татвар ногдуулах орлогын хэмжээ 3,1 сая төгрөгөөр буурч, энэ нь орлогын албан татварын ачааллыг 0,6 сая төгрөгөөр бууруулсан байна.

Хоршоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор хадгаламж зээлийн хоршоодын эрсдэлийн сан, бусад үйл ажиллагаа явуулдаг хоршоодын болзошгүй алдагдлыг нөхөх нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгийг татвар ногдох орлогоос хасч тооцохоор аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Ингэснээр хоршоодын татварын ачаалал жилд ойролцоогоор 0,3 сая төгрөгөөр буурах боломжтой болжээ.

Үүний зэрэгцээ Үндэсний татварын ерөнхий газраас аж ахуйн нэгж, байгууллагуудад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж иржээ.

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн судалгаа

(мянган төгрөгөөр)

№	Хуулийн заалт	Хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан				Өсөлт, бууралт	
		Аж ахуйн нэгжийн тоо		Дүн		тоо	Дүн
		2002 он	2003 он	2002 он	2003 он		
1	ААНБОАТ-ын хуулийн 7.2	4	13	113553,8	21969,9	9	(91583,9)
2	ААНБОАТ-ын хуулийн 7.3	110	239	32642,7	362135,4	129	329492,7
3	ААНБОАТ-ын хуулийн 7.11	16	21	52117,2	307491,9	5	255374,7
4	ААНБОАТ-ын хуулийн 7.5.1	6	6	3789964,5	7128378,1	-	3338413,6
5	ААНБОАТ-ын хуулийн 7.5.2	4	2	84616,8	95094,0	(2)	10477,2
6	ААНБОАТ-ын хуулийн 7.6	42	24	797981,5	322951,7	(18)	(475029,6)
	Дүн	182	305	4870876,5	8238021,0	123	3367144,7

Үндэсний татварын ерөнхий газрын хэмжээгээр 2003 онд 305 аж ахуйн нэгжийн 8238,0 сая төгрөгийн орлогыг татвараас хөнгөлсөн буюу чөлөөлсөн нь өмнөх оноос 123 аж ахуйн нэгжээр буюу 3367,1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын дүн

ААНБОАТ-ын хуулийн 7.3, 7.11 дэх заалтын дагуу хөнгөлөлт эдэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 2002 онд 126 байсан бол 2003 онд 260 болж татвар төлөгчдийн тоо 134 аж ахуйн нэгжээр, хөнгөлөлтийн хэмжээ өмнөх оноос 584,8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх салбаруудад явуулж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын үр дүнд татвар төлөгчдийн татварын ачааллыг бууруулж, татварын хувийг хөнгөлснөөр энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн тоо өсч, татварын баазыг өргөтгөх боломж нэмэгджээ.

ААНБОАТ-ын хуулийн 7.2, 7.5.1, 7.5.2, 7.6 дахь заалтын дагуу үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн тоо багасч, нийт хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнд эзлэх хувийн жин өмнөх оноосоо 6,4 хувиар буурчээ.

Иймд гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагад баримталж байгаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогод өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Дотоодын хөрөнгийн эх үүсвэрийн дутагдлыг нөхөх, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, техник технологийн шинэчлэлт хийх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бодлого баримталбал татварын бааз суурийг өргөтгөх боломж бүрдэх юм.

Үндэсний татварын ерөнхий газраас эдийн засгийн өсөлтийг татварын бодлогоор зохицуулахад үйлчлэл, үр нөлөө багатай хуулийн заалтуудыг хүчингүй болгох, зарим заалтын найруулгыг тодорхой болгох төслийг 2002 онд УИХ-аар батлуулж, тайлант онд хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дахь заалт буюу Донорын цус, цусан бүтэгдэхүүн, эд эрхтэнийг эмчилгээнд хэрэглэснээс олох орлогыг татвараас чөлөөлж байсныг хүчингүй болгожээ.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдаж авах хэлбэрээр байгуулагдах гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлт, чөлөөлөлт хамаарахгүй байхаар тусгажээ.

Аудитын дүн

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын чөлөөлөлтийн судалгаа

(мянган төгрөгөөр)

№	Хуулийн заалт	чөлөөлөлтөд хамрагдсан				Өсөлт, бууралт	
		Аж ахуйн нэгжийн тоо		Дүн		тоо	Дүн
		2002 он	2003 он	2002 он	2003 он		
1	З.Г-ын зээллэгийн хүүгийн орлого	7	8	5613224,9	4281601,5	1	(1331623,4)
2	ТББ-ын гишүүд, дэмжигчдийн татвар, хандив	14	13	49118,6	104173,1	(1)	55054,5
3	ДЦЦБ, ЭЭЭХ ООрлого	1		11773,2		(1)	(11773,2)
4	НД болон НХС орлого	4	4	230877,0	274722,0	-	43845,0
5	ТББ орлого	15	4	403547,1	38770,5	(11)	(364776,6)
6	ОУ, ОН-ын зам засвар	1	3	12870,0	1567203,4	2	1554333,4
7	ГХО дахин хийх	8	3	1951948,6	719342,6	(5)	(1232606,0)
	Дүн	50	35	8273359,4	6985813,1	(15)	(1287546,3)

Ийнхүү Үндэсний татварын ерөнхий газрын хэмжээгээр татварын хууль тогтоомжийн хүрээнд 2003 онд 35 аж ахуйн 6985,8 сая төгрөгийн орлогыг татвараас чөлөөлсөн нь өмнөх оноос 1287,5 сая төгрөгөөр буурсан байна.

Хуулийн заалтын найруулгыг тодорхой болгох, зарим нэр томъёог татварын бусад хуультай нийцүүлэх үүднээс гадаад валютаар олсон орлогыг төгрөгт шилжүүлэхдээ уг валютыг банкинд худалдах тухайн өдрийн Монголбанкнаас тогтоосон ханшийг үндэслэж байхаар Хүн амын орлогын албан татварын хуулийн 4 дэх зүйлд өөрчлөлт оруулан 2003 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

1996 онд хүчин төгөлдөр болсон Гаалийн тухай хуульд 7 удаа, Гаалийн тарифын тухай хуульд 6 удаа нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Татварын уян хатан бодлогын дагуу шаардлагагүй импортыг багасгах, экспортыг хөхүүлэн дэмжих, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, тэдний бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх, эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэхэд гаалийн тарифын зохистой тогтолцоог бүрдүүлж гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Аудитын дүн

УГЕГ-ын Бүрдүүлэлтийн дараах шалгалтын хэлтсээс гадаад тээвэр, зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг 31 байгууллагад хийсэн шалгалтын дүнгээс харахад гадаад тээврийн зардлын тодорхойлолтыг харилцан адилгүй тарифаар тодорхойлж өгснөөр гаалийн татварыг дутуу ногдуулах зөрчил гарч байжээ.

Тухайлбал, Улаанбаатар хот дахь Гаалийн газарт 2003 онд бүрдүүлэлт хийсэн Эм Эн Ложистик ХХК, Материалимпекс ХК-ийн тээвэр зуучлалын алба, МТТ ХХК, Монголтранс ХХК, Уорлд транс ХХК, Прогресс транс ХХК зэрэг байгууллагууд гаалийн татвар тооцох гадаад тээврийн зардлыг гаалийн байгууллагад дутуу тодорхойлсноос 32,9 сая төгрөгийн татварыг төсөвт оруулах боломжийг алджээ.

Импортын барааны тодорхой нэр төрөл дээр гаалийн татварыг ялгавартай тогтоож, гаалийн бодлогыг боловсронгуй болгох нь чухал юм. Тухайлбал, зарим нэр төрлийн барааны (хуучин автомашин, хуучин дугуй, дотоодод үйлдвэрлэж байгаа хүнсний бараа, бүтээгдэхүүн, савхи, нэхий, ноолууран эдлэл, хивс, гэх мэт) импортыг хязгаарлах үүднээс гаалийн татварыг нэмэгдүүлж болох юм.

Олон улсын зарим гэрээний гаалийн болон бусад татвараас чөлөөлөхтэй холбогдсон заалтууд өнөөгийн шаардлагад нийцэхгүй байна. Тухайлбал, “Улаанбаатар төмөр зам” Монгол, Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэгийг байгуулах тухай БНМАУ-ын Засгийн газар, Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хоорондын 1949 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээрийн 10 дугаар зүйлд “...Түүнчлэн төмөр замын орлого хийгээд мөн замаар болон 8 дугаар зүйлийн “д”-д заасан гол мөрнүүдээр ачаа тээш ба хүмүүсийг тээвэрлэх явдал болон төмөр замын өмчид буюу ашиглалтад байгаа газруудын хийгээд төлбөрийн эд хогшилд БНМАУ-ын дотор байгаа буюу ирээдүйд бий болж болох ямар нэгэн албан татварыг үл ногдуулна” гэж заасан байдаг.

Зөвхөн 2003 онд Улаанбаатар Төмөр зам 29,1 сая ам.долларын, 2004 оны эхний 9 сарын байдлаар 39,4 сая ам.долларын үнэ бүхий дизелийн түлш, материал, сэлбэг хэрэгслийг улсын хилээр оруулж, улмаар гэрээний дээрх заалтыг үндэслэн 2003 онд 7395,2 сая төгрөгийн, 2004 оны эхний 9 сарын байдлаар 9994,7 сая төгрөгийн гаалийн татвараас чөлөөлөгджээ.

Аудитын дүн

УБТЗ-ын улсын хилээр оруулж байгаа дизел түлш болон материал сэлбэгийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа юм. 2003 онд чөлөөлөгдсөн гаалийн татвар 55,5 тэрбум төгрөг буюу 13,3 хувь, 2004 оны эхний 9 сарын байдлаар 52,8 тэрбум төгрөг буюу 18,9 хувиар өсчээ.

Дээрх гэрээний 10 дахь зүйлд заасан “төмөр замын өмчид буюу ашиглалтад байгаа газруудын хийгээд төлбөрийн эд хогшилд БНМАУ-ын дотор байгаа буюу ирээдүйд бий болж болох ямар нэгэн албан татварыг үл ногдуулна” гэсэн заалтаас төлбөрийн эд хогшилд гэдэг зүйлд дизел түлш болон бусад бараа материал, сэлбэг хэрэгслийг бүрэн хамруулж байна.

Иймд Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэгийг байгуулах тухай БНМАУ-ын Засгийн газар, Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хоорондын 1949 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээрийг хоёр улсын Засгийн газрын хооронд дахин хянан хэлэлцэж, татварын асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Одоогийн нөхцөлд барааны нэр төрөл, бүс нутаг, салбар үйлдвэрлэгчээр ялгавартай тариф тогтоохтой холбогдуулан татварын бодлогын ардчилсан шинж чанарыг алдагдуулахгүйгээр тарифын зохистой бүтцийг бий болгох, түүнчлэн дотоодын үйлдвэрлэлийн шударга өрсөлдөөнийг дэмжиж, тодорхой салбарын монополичлолыг халах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Засгийн газар олон улсын гэрээ байгуулахдаа гагцхүү ашигтай зээл, тусламж авахад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг хөндөх эрхтэй байх эрхийн хязгаарлалтыг хуульчилж өгөх нь зүйтэй байна.

Татварын ногдуулалт, төлөлтөд тавих дотоод хяналтын тогтолцоо, түүний чанар, үр нөлөө

Үндэсний татварын ерөнхий газрын Хяналт шалгалтын хэлтэс 2003 онд татварын хяналт шалгалтын ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, татвар төлөгчдийн талаар цуглуулсан мэдээллийг татварын хяналт шалгалтад ашиглах, хяналт шалгалтын хэлтэс, тасгийн ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт шалгалтын байдалд тогтоосон стандартыг хангах зорилт тавьж ажилласан байна.

Үндэсний татварын ерөнхий газрын хэмжээнд тайлант хугацаанд татварын хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчдөд 14002,4 сая төгрөгийн нөхөн татвар, хүү, торгууль ногдуулснаас 49,1 хувь буюу 6875,4 сая төгрөгийг барагдуулсан байна.

Аудитын дүн

Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2003 оны 230 дугаар тушаалаар баталсан “...Татвар төлөгчийн зөвшөөрсөн татварын улсын байцаагчийн актаар ногдуулсан нөхөн татвар, хүү, торгуулийн барагдуулалтын 80-аас доошгүй хувь нь төлөгдсөн байх” гэсэн гүйцэтгэлийн стандартыг Төвлөрсөн төсвийн орлого хяналтын газар, нийслэл, дүүрэг, аймгуудын татварын хэлтсүүдийн 75 хувь нь хангаж ажлаагүй байна.

Зөвхөн Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Увс зэрэг 7 аймгийн татварын хэлтэс болон Хан-Уул дүүргийн татварын хэлтэс дээрх стандартыг 80,6-95,4 хувиар хангаж ажилласан байна.

Үндэсний татварын ерөнхий газрын Хяналт шалгалтын хэлтэс 2003 онд 116 татвар төлөгчийг шалгалтад хамруулсны 67 нь хяналт шалгалтын графикаар, 26 нь мэдээллээр, 16 нь тусгай удирдамжаар, 4 нь ҮТЕГ-ын шийдвэрээр, 3 нь хууль хяналтын байгууллагын хүсэлтээр тус тус шалгагджээ.

Шалгалтаар нийт 29597,0 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлсний 80,3 хувь буюу 23794,5 сая төгрөг, 1164,678,0 ам долларын төлбөр, зөрчил илрүүлсний 59,4 хувь буюу 691728 ам. долларын төлбөр, зөрчлийг тус тус хууль, хяналтын байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн байна.

Тус хэлтэс тайлант оны шалгалтаар төлүүлэхээр шийдвэрлэсэн нөхөн татвар 579,5 сая төгрөг, хүү 257,3 сая төгрөг, торгууль 72,6 сая төгрөг, бүгд 909,4 сая төгрөгийн төлбөр ногдуулжээ.

Хяналт шалгалтаар төлүүлэхээр шийдвэрлэсэн нийт ногдуулалтын 46,4 хувь буюу 422,0 сая төгрөгийг барагдуулсан байна.

Тайлант онд хяналт шалгалтын актаар тавигдсан нийт барагдаагүй өр 487,2 сая төгрөг байгаагийн 46,7 хувийг нь эзлэх “Гурван хүрд” ХХК, “Гурван-Од” ХХК, “Баавар” ХК, “Бэрх-Уул” ХК, “Жол” ХК, “Хэт” ХХК зэрэг 21 аж ахуйн нэгж, компаниуд нэг ч төгрөгийн төлбөр хийгээгүй, 53,3 хувийг эзлэх “Хөвсгөл хүнс” ХК, “Баян-Уул” ХК, “Монгол-Алт” ХХК, “Увс хүнс” ХК, “Престиж” ХХК зэрэг 22 татвар төлөгч 0,04-22,0 сая төгрөг дутуу төлсөн байна.

Татварын хяналт шалгалтад алдагдалтай тайлан ирүүлсэн татвар төлөгчийг хамруулсан байдлыг Мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтсийн AUDIT программын мэдээ, Татварын удирдлага арга зүйн хэлтсийн үнэлгээний тайланг үндэслэж дүгнэхэд 2002 оны жилийн

Аудитын дүн

эцсийн орлогын албан татварын тайлангаар алдагдалтай тайлан ирүүлсэн 3088 татвар төлөгчийн 38,7 хувийг буюу 1196 аж ахуйн нэгж, байгууллагыг хяналт шалгалтад хамруулсан байна.

Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2003 оны 230 дугаар тушаалаар баталсан *"...Өмнөх оны аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тайлангаар алдагдалтай байсан татвар төлөгчийг татварын хяналт шалгалтад хамруулсан байдал аймаг, дүүргийн татварын хэлтэст 50,0-ас доошгүй хувийг хамруулсан байна"* гэсэн гүйцэтгэлийн стандартыг нийт аймаг, дүүргийн татварын хэлтсийн 80 хувь нь хангаж ажиллаагүйн зэрэгцээ Архангай, Баянхонгор аймгуудын татварын хэлтсүүд алдагдалтай тайлан ирүүлсэн татвар төлөгчдөөс нэгийг нь ч татварын хяналт шалгалтад хамруулаагүй байна.

Хяналт шалгалтын хэлтэс татвар төлөгчдийг татварын хяналт шалгалтад хамруулах талаар Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2003 оны 230 дугаар тушаалаар баталсан дээрх гүйцэтгэлийн стандартуудыг хангах талаар тодорхой бодлого боловсруулж ажиллаагүй байна.

Хяналт шалгалтын хэлтсээс 2000-2003 онд нийслэл, аймаг, дүүргүүдийн татварын хэлтсүүдийн шалгасан 68 аж ахуйн нэгжүүдэд татварын давхар хяналт шалгалт явуулж урьд гарсан төлбөр зөрчлөөс 4 дахин их буюу 16081,2 сая төгрөгийн зөрчил шинээр нэмж илрүүлсэн байна.

Дээрх шалгалтаар албан татвар ногдох их хэмжээний орлого нуусан, албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн, онцгой албан татварын хуурамч тэмдэг ашигласан зэрэг 13434,7 сая төгрөгийн зөрчил төлбөр гаргасан "Анома", "Жамп", "Престиж", "Санкредит групп" ХХК зэрэг 27 татвар төлөгчдийг Улсын мөрдөн байцаах газар, Хэрэг бүртгэлийн газар, Эрүүгийн цагдаагийн газарт тус тус шилжүүлжээ.

Тухайн онд хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн акт, дүгнэлтээс нэг нь ч шийдвэрлэгдээгүй байна.

Зарим төлбөр, зөрчлийг үл зөвшөөрч маргаантай байсан "Рокмон сосей" ХХК нь Үндэсний татварын ерөнхий газрын Татварын маргаан таслах зөвлөлд хандсан байна.

Аудитын дүн

Татварын маргаан таслах зөвлөлийн 2003 оны 5 дугаар сарын 29-ний хурлаар Рокмон Сосей ХХК-ний үүсгэсэн маргааныг хэлэлцээд Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 7-гийн "Г" болон 13 дугаар зүйлийг удирдлага болгон Татварын улсын байцаагчийн актыг хэвээр баталсан байна.

Татварын давхар хяналт шалгалт тогтмол хэрэгжснээр татварын байцаагчдыг авилгалд өртөх, татвар төлөгчтэй үгсэн хуйвалдах зэрэг ёс зүйн алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх, мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх ач холбогдолтой юм.

Харин татварын давхар хяналт шалгалтын мөрөөр байцаагчийн ёс зүй зөрчсөн, татварын байцаагч нарт хүлээлгэх хариуцлагын тогтолцоог татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрэмд тодорхой тусгаж өгөх хэрэгтэй байна.

Гаалийн байгууллагууд гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулсан мэдээллийн үндсэн дээр хийж, барааг шууд эзэнд нь олгож, гаалийн болон санхүүгийн баримтад тодорхой хугацаанд төлөвлөгөөт болон мэдээллийн үндсэн дээр бүрдүүлэлтийн дараах шалгалтыг тухайн аж ахуйн нэгж байгууллагад хийж байна.

Уг шалгалтыг явуулах эрх зүйн үндэс нь 1996 онд шинэчлэн найруулан баталсан Гаалийн тухай хуулийн 43 дугаар зүйл, УГЕГ-ын 1997 оны 437 дугаар тушаалаар баталсан "Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх тухай журам" бөгөөд уг журмыг 2001 онд шинэчлэн батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

2003 онд бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалтыг 100 аж ахуйн нэгж, иргэнд хийж, 55 актаар бүгд 420,3 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, үүнээс 127,1 сая төгрөгийг барагдуулж, 84,1 сая төгрөгийн төлбөрийг хуулийн байгууллагад шилжүүлжээ.

Аж ахуйн нэгж, иргэнд хийсэн бүрдүүлэлтийн дараах шалгалтаар аж ахуйн нэгж, иргэд барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, гадаад тээврийн зардлыг худал мэдүүлэх, хуурамч баримт бүрдүүлж гаалийн бүрдүүлэлт хийх, горим буруу сонгосон, түр хугацаагаар оруулсан барааг хугацаанд нь буцаан гаргаагүй тохиолдолд бүрмөсөн гарснаар тооцож гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй, татвараас чөлөөлөгдсөн барааг өөр зориулалтаар ашигласан, компаниуд татвараас зайлсхийж хувь хүний нэрээр бүрдүүлэлт хийсэн бараагаа орлогод аваагүй зэрэг нийтлэг зөрчил илэрч байжээ.

Аудитын дүн

2003 онд Улаанбаатар, Буянт-Ухаа, Баян-Өлгий, Увс, Ховд дахь гаалийн газар, хороодод хийсэн шалгалтаар улсын хилээр нэвтрүүлж байгаа бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах бүртгэл хөтлөлт хангалтгүй, гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримт дутуу, засварласан, сольсон, хуулбарласан, гаалийн лабораторийн дүгнэлтгүй, лицензгүй, барааны нэр төрөл тоо хэмжээ зөрсөн, гаалийн үнэ үнэлгээг хэт бага байхад бүрэн хянаагүй, гадаад тээврийн зардлыг хэрхэн мэдүүлж байгааг анхаараагүй, түүнийг баримтжуулаагүй, тооцоот хуудасны бүртгэлд хяналт тавиагүй, гаалийн улсын байцаагч нар хураасан татварын мөнгийг хугацаа хэтрүүлэн тушаадаг, тооцоот хуудас үрэгдүүлсэн, засварласан, төсвийг хэтрүүлэн зарцуулсан зэрэг нийтлэг зөрчил илэрч, 12 актаар 13,1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, барагдуулжээ.

Бүрдүүлэлтийн дараах шалгалтын хэлтэс нь гаалийн татварын ногдуулалт, төлөлтөд хяналт тавих чиг үүргээ биелүүлж байгаа боловч, гарсан зөрчилд төлбөрийн акт тогтоон холбогдох байгууллага, иргэдээр төлүүлэх ажил шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Тус хэлтэс шалгалтаар илрүүлсэн төлбөрийг барагдуулсан тухай тайлагнаж байгаа боловч төлбөрийг байцаагч нэг бүрээр тогтоосон актын дүнгээр нь бүртгэж, үүнээс барагдуулсныг хасч, үлдэгдлийг бүртгэлд тусган хяналт тавих ажил хангалтгүй байна.

“Хар төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийг түүхий эдээр дутагдаж байхад энэхүү үйлдвэрийн түүхий эд болох хаягдал төмөр өмнөд хөршид гарсаар байна.

Хар төмрийн гаалийн татварыг нэмэгдүүлсэн боловч төмөр гаргагч байгууллага, хүмүүс төмөр болон барааны жин, тоо хэмжээнд хяналт тавих боломжгүй газраар төмөр гаргаж байна.

Тухайлбал, Дорноговь аймгийн “Ханги мандал” хилийн боомтод гаалийн хяналтын 100 тн-ын даацын пүү 2004 оны 5 дугаар сарын 15-наас өнөөг хүртэл ажиллахгүй байна. Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт байдаг “Бичигт” боомт дахь 100 тн-ын даацын цахилгаан пүү 2004 оны 7 дугаар сарын 3-наас хойш мөн ажиллахгүй, гаалийн хяналт хийх боломжгүй байгаа юм. Дээрх 2 боомтоор гарч байгаа хар төмөр болон малын гаралтай түүхий эд, хүнсний барааны тоо, хэмжээг тогтоохдоо машины даацаар тооцоо хийж, байгууллага, хүмүүс машины даацыг хэтрүүлэн ачиж, гаалийн татвараас зайлхийх боломж олгож байна.

Аудитын дүн

Татварын бүртгэл, мэдээллийн тогтолцооны найдвартай, шуурхай байдал

Үндэсний татварын ерөнхий газрын Мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтэс татварын албаны мэдээллийн системийг нээлттэй бүтэцтэй, клиент-сервер архитектуртай, орчин үеийн мэдээллийн ORACLE систем ашиглан үүсгэн байгуулж ажиллуулжээ.

Энэ ажлын хүрээнд татварын хэлтэс бүрт мэдээллийн шинэ локал серверийг суурилуулан, 4-32 хэрэглэгчийн клиент-сервер системийн дотоод сүлжээнд холбон ажиллуулж байна.

Үндэсний татварын ерөнхий газар дараахь 40 гаруй тусгай програмыг ашиглаж байна. Үүнд:

- Байгууллагын чиг үүргийн хэрэгцээнд “Oracle 9i dbc”, “Debt management”, “Status”, албан хэрэг хөтлөлт, захидал харилцаа, өргөдөл гомдол зэрэг 33 программ
- Удирдлагын хэрэгцээнд “Employee” программ
- Дотоод хяналтын хэрэгцээнд “TPI”, албан бичгийн хөтлөлтийн программ зэрэг 4 программ
- Санхүүгийн хэрэгцээнд Macs Accounting-2000 программыг хэрэглэж байна.
- Хэрэглэгчдийн хэрэгцээнд “Хэрэглэгчийн бүртгэл” программыг шинээр зохиож нэвтрүүлсэн байна.

Дээрх ашиглагдаж байгаа програмын 15 хувь нь албан ёсны зөвшөөрөл, лицензтэй програмууд байна.

Үндэсний татварын ерөнхий газрын хэмжээнд мэдээллийн технологийн чиглэлээр бэлтгэгдсэн 9 боловсон хүчин ажиллаж, Пилот болон бусад чиглэлийн сургалтад давхардсан тоогоор 115 хүн хамрагдсан гэсэн дүн мэдээ гарчээ. Дээрх бэлтгэгдсэн хүмүүсийн 8 хувь нь өөр газар шилжиж ажилласан байна.

Мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтэс “Татвар төлөгчдөд нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны түр журам”-ыг боловсруулан Үндэсний татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулан 2003 онд Хан-Уул, Баянгол дүүргүүдийн татварын хэлтэст туршин нэвтрүүлж, мэдээлэл боловсруулалтын төвлөрсөн бус тогтолцоонд шилжүүлэн, үйл ажиллагааны албадаар гүйцэтгүүлэх ажлыг 2004 оноос эхлэн хэрэгжүүлжээ.

Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлснээр татвар төлөгчдөд үйлчлэх ажиллагаанд дэвшил гарч, татвар хураалтын асуудлаар оновчтой шийдвэр гаргах, татварын улсын байцаагчдын ажлыг хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлд түлхүү зохион байгуулах боломжийг бүрдүүлж байна.

Аудитын дүн

Одоогийн байдлаар ҮТЕГ-ын ажилтнуудын 83,7 хувь, нийслэлийн татварын газрын ажилтнуудын 83,0 хувь, дүүргийн татварын хэлтсийн ажилтнуудын 45,6 хувь, аймгуудын татварын хэлтсүүдийн 59,9 хувь, сумдын татварын байцаагчдын 11,3 хувь нь компьютерээр хангагдсан байна.

Сүхбаатар аймгийн татварын хэлтсийн татварын байцаагч нарын компьютер хангалтын хувь 45,8 хувьд хүрчээ. Тус аймгийн Түмэнцогт сумын татварын байцаагчаас бусад сумдын татварын байцаагч нар компьютергүй байгаа нь эрчим хүчний байнгын найдвартай эх үүсвэргүйтэй холбоотой байна.

Энэ байдал нь татвар төлөгчдөд нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа болон мэдээлэл боловсруулалтын төвлөрсөн бус тогтолцоонд шилжүүлэн орчин үеийн татварын алба болоход бэрхшээл учруулж болзошгүй юм.

Татварын газар, хэлтсүүдэд татвар төлөгч тус бүрээр татварын мэдээллийн бааз байгуулагдсан ч түүнийг татварын ногдуулалт, төлөлт болон хяналт шалгалтын ажилд бүрэн ашиглах явдал шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

2002 оны 10 дугаар сараас эхлэн гаалийн байгууллагын Гаалийн Албаны Мэдээллийн Автоматжуулсан Систем (ГАМАС) гэж нэрлэсэн мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болжээ.

ГАМАС-ийн давуу тал нь сүлжээний горимд клиент-сервер технологи дээр суурилагдсан, програмууд нь WINDOWS-ийн орчинд ажилладаг, монгол хэл дээр бичигдсэн учраас ашиглахад хялбар, мэдээллийн бааз нь хамгийн сүүлийн үеийн DataBase технологүүдын нэг болох SQL-2000 систем ашигладаг, гаалийн байгууллагын анхны үндэсний систем учраас цаашид програм хангамжуудыг шинээр хийх, боловсронгуй болгож өөрчлөх боломжтой юм.

ГАМАС программыг нэвтрүүлснээр гаалийн болон зуучлагч, аж ахуйн нэгж байгууллагад үйлчлэх цаг хугацааг хэмнэж, ажлын давхардлыг арилган, үйлчилгээг хөнгөн шуурхай болгоход нилээд ахиц гарч, улмаар гаалийн бүрдүүлэлтийн цогц үйл ажиллагаа, мэдээ мэдээлэл, төлбөр тооцооны ажлыг хөнгөвчилж байна.

Аудитын дүн

Улсын гаалийн ерөнхий газар Сэлэнгэ, Замын-Үүд дэх Гаалийн газруудтай агаарын сүлжээний аргаар (visat), Улаанбаатар хот дахь Гаалийн газартай шилэн кабелийн сүлжээгээр (online), Улаанбаатар дахь гаалийн газар терминалуудтай утсан холбоогоор холбогдсон байна.

Гэвч OnLine шилэн кабелийн сүлжээ гаалийн бүх байгууллагыг хамраагүй (Зөвхөн Улаанбаатар дахь гаалийн газар, Замын-Үүд, Сэлэнгийн гаалийн газар OnLine сүлжээнд холбогдсон), OnLine сүлжээнд хамрагдаагүй газруудыг төвөөсөө шууд хяналт тавьж чадаагүй, эдгээр газруудаас мэдээ тайлан хоцорч ирдэг, гаалийн байцаагч нар энэ систем дээр ажиллах чадвар муу, нэгдсэн сургалт зохион байгуулаагүй байна.

Дүгнэлт

Аудитын явцад олж бүрдүүлсэн нотлох зүйлс, баримт материал, хийсэн ажиглалт, судалгаанд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- УТЕГ, УГЕГ 2003 онд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын болон гаалийн албан татварын ногдуулалт, төлөлт урьд жилүүдээс өсч байгаа нь холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар үр дүнтэй ажиллажээ.
- Улсын төсөвт орох татварын орлого болон татвар төлөгчдийн тоо 2003 онд өмнөх оноос нэмэгдэж татварын бааз суурь өргөжиж байна.
- Татварын мэдээ, тайлан зөрүүтэй гарч байгаад дүгнэлт хийж, татвар төлөгчид болон олон нийтэд татвар төлөлтийг үнэн зөв мэдээлж байх хугацааг хуульчилж өгөх нь зүйтэй юм.
- Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэгийг байгуулах тухай БНМАУ-ын Засгийн газар, Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хоорондын 1949 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээрийг хоёр улсын засгийн газрын хооронд дахин хянан хэлэлцэж, татварын асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.
- Үндэсний татварын ерөнхий газрын хяналт шалгалтын хэлтэс татвар төлөгчдийг татварын хяналт шалгалтад хамруулах гүйцэтгэлийн стандартуудыг хангаж ажиллаагүй байна.
- Татварын давхар хяналт шалгалтын мөрөөр байцаагчийн ёс зүй зөрчсөн, татварын байцаагч нарт хүлээлгэх хариуцлагын тогтолцоог татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрэмд тодорхой тусгаж өгөх хэрэгтэй байна.
- УГЕГ-ын Бүрдүүлэлтийн дараах шалгалтын хэлтэс шалгалтаар илрүүлсэн төлбөрийг барагдуулсан тухай мэдээ тайланг зохих журмын дагуу бүртгэлд тусгаж өгөх хангалтгүй байна.

Дүгнэлт

- Үндэсний татварын ерөнхий газар татварын албаны мэдээллийн системийг нээлттэй бүтэцтэй, клиент-сервер архитектуртай, орчин үеийн мэдээллийн ORACLE систем ашиглаж, Улсын гаалийн ерөнхий газар 2002 оноос эхлэн гаалийн байгууллагын Гаалийн Албаны Мэдээллийн Автоматжуулсан Систем (ГАМАС) гэж нэрлэсэн мэдээллийн нэгдсэн тогтолцоотой болжээ.
- ҮТЕГ, УГЕГ-т татварын мэдээллийн бааз байгуулагдсан ч түүнийг татварын ногдуулалт, төлөлт болон хяналт шалгалтын ажилд бүрэн ашиглах байдал хангалтгүй байна.

Үндэсний
татварын
ерөнхий
газраас
ирүүлсэн
санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ


**ҮНДЭСНИЙ
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жигжиджавын гудамж 6, Утас: 32-01-67, Факс: 32-76-86,
E-mail: info@mta.pmis.gov.mn

2007.11.11 № 1/209
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн албан татварын орлогын
бүрдүүлэлтэд хийсэн аудитын тайланг хүлээн авлаа.
Аудитаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу цаашид
ажил зохион байгуулах болно.



Л.Зориг

09 5067

Санал

Гаалийн
ерөнхий газраас
ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

210620 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их тойруу 81/1, Утас: 35-00-54, Факс: 35-00-60

E-mail: gaali@customs.pmis.gov.mn;


<http://www.customs.pmis.gov.mn>

2004-11-09 № 13454
танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАРТ**

Танай газраас гаалийн байгууллагын 2003 оны гаалийн татварын орлогын бүрдүүлэлтэд хийсэн шалгалтын тайлантай танилцлаа. Тайланд тусгасан дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлэн ажиллах болно.




Х.БААТАР

010562

Зөвлөмж

Гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

ҮТЕГ –ын дарга Л.Зоригт:

- Зарим татвар төлөгчдөд ногдуулсан татварыг хуулийн хугацаанд бүрэн төлүүлэх ажлыг цаашид сайжруулахад чиглэгдсэн ажил зохион байгуулах
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар явуулж байгаа одоогийн бодлого, арга зүйг шинэчлэн боловсруулах замаар төсвийн орлогын өсөлтийг хангахад чиглэгдсэн арга хэмжээ авах
- Үндэсний татварын ерөнхий газрын татварын хяналт шалгалтын ажлын зохион байгуулалт, бүтэц болон ажил үүргийн хуваарийг шинэчлэн боловсруулах замаар хяналт шалгалтын бодлого боловсруулах болон татвар төлөгчдөд хяналт шалгалт хийж байгаа одоогийн ажлын зааг ялгааг цаашид тодорхой болгох
- Компьютер, техник хэрэгслийн ашиглалтыг сайжруулж, татвар төлөгчдийн талаарх мэдээлэл боловсруулах тусгай программ хангамжийн боломж давуу талыг үйл ажиллагаандаа бүтээлчээр ашиглах

Улсын гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатарт:

- Ногдуулсан гаалийн татварыг улсын төсөвт хугацаанд нь барагдуулах талаар гаалийн байгууллагын удирдлага, ажилтнууд цаашид анхаарч ажиллах
- Гаалийн татварын чөлөөлөлттэй холбогдож Засгийн газар олон улсын гэрээ байгуулахдаа гагцхүү ашигтай зээл, тусламж авахад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг хөндөх эрхтэй байх эрхийн хязгаарлалтыг хуульчилж өгөх асуудлыг судлаж шийдвэрлүүлэх
- Тээвэр зуучийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд Гаалийн байгууллагад гадаад тээврийн зардлын тарифыг харилцан адилгүй бичиж, гаалийн үнэд гадаад тээврийн зардлыг дутуу тусгаснаар гаалийн татварыг дутуу ногдуулах зөрчил гарч байгаад дүгнэлт хийж, тухайн байгууллагатай хариуцлага тооцож ажиллах

Зөвлөмж

- Гаалийн бүх газар хороодыг нэгдсэн OnLine сүлжээнд холбох, нэгдсэн нэг төвлөрсөн хяналтын системтэй болох, гаалийн байцаагч нарын ГАМАС систем дээр ажиллах чадварыг нэмэгдүүлэх, уг системийг улам боловсронгуй болгох арга хэмжээ авах
- Гаалийн татвартай холбогдсон зарим аж ахуйн нэгж байгууллагад хийсэн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах ажлыг зохион байгуулах

Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Г.Батхүүд зөвлөмж болгох нь:

- Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэгийг байгуулах тухай БНМАУ-ын Засгийн газар, Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хоорондын 1949 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээрийг хоёр улсын засгийн газрын хооронд дахин хянан хэлэлцэж, татварын асуудлыг судлаж шийдвэрлэх

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

Үндэсний аудитын газрын
Тэргүүлэх аудитор

Д.ГАНБИЛЭГ